



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/272

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны XXV/05 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний “Байгаль хамгаалагчдын компьютер, техник хэрэгсэл худалдан авах” төсөл арга хэмжээг цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар зарлаж, нийлүүлэгчээр “Ай ти зон” ХХК шалгарч, 62,575,000 (жаран хоёр сая таван зуун далан таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

2. Тус хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу гэрээ, акт байгуулан хүлээн авч данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Дээрх бараанд шаардагдах хөрөнгийг холбогдох хууль журам, гэрээний дагуу Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Цэдэнлхам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

